



ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

№ .03

(Багануур дүүрэг)

2016 оны 02-р сарын 02-ны өдөр

Нэг талаас Тогосын хөндий ХХК-ийг төлөөлөн захирал А.Хадхүү (цаашид "Худалдагч" гэнэ) нөгөө талаас БҮТПарк ОНӨТҮГ-ыг төлөөлөн аж ахуйн дарга, нярав С.Алтантана (цаашид "Худалдан авагч" гэнэ) нар хамтран энэхүү гэрээг дараахь нөхцөлтэйгээр байгуулав.

1. Нийтлэг заалт

1.1. Гэрээний нөхцөлийн дагуу Худалдагч нь биет байдлын болон эрхийн доголдолгүй компьютер, ширээ, сандал, шкаф, аж ахуй, бичиг хэрэг, цэвэрлэгээний болон бүхий л бараа материал бусад (цаашид "Бараа" гэнэ) түүнтэй холбоотой баримт бичгийг Худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх, Худалдан авагч нь хөрөнгийг хүлээн авч, төлбөрийг хийнэ.

1.2. Худалдагчаас шилжүүлж байгаа бараа нь чанар, улсын стандарт, техникийн нөхцөл, эрх зүйн актаар тодорхойлогдсон иж бүрдлийг хангаж байна.

1.3. Гэрээний үйлчлэх хугацаанд барааны үнийг зах зээлийн ханшаар өөрчилж болно

2. Худалдагчийн үүрэг

- Худалдагч нь дараахь эрх, үүрэг хүлээнэ.

2.1. Худалдагч нь захиалгын дагуу бараа материалыг нийлүүлэхээс 3 хоногийн өмнө утсаар худалдан авагчид хөрөнгө шилжүүлэх талаар мэдэгдэнэ.

2.2. Гэрээний салшгүй хэсэг болох нэхэмжлэх зарлагын баримт бусад шаардлагатай баримтыг Худалдан авагчид шилжүүлэн өгнө.

2.3. Худалдагч нь нийлүүлэх барааны чанар аюулгүй байдал, тээвэрлэлтийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж эвдрэл гэмтэл, гологдлыг бүрэн хариуцна.

3. Худалдан авагчийн үүрэг

- Худалдан авагч дараахь үүрэг хүлээнэ.

3.1. Худалдагчаас барааг шилжүүлэх хугацааг мэдэгдсэнээс 3 хоногийн дотор барааг хүлээж авна.

3.2. Барааг хүлээж авахдаа тоо, чанар, иж бүрдлийг шалгаж, баримт бичгийг бүрдүүлнэ.

3.3.Худалдаж авсан барааг шалгах болон ашиглах явцад илэрсэн доголдлыг Худалдагчид мэдэгдэнэ.

3.4. Худалдаж авсан барааны төлбөрийг нэхэмжлэлийн дагуу цаг хугацаанд нь төлөх үүрэгтэй.

4. Тооцоо хийх журам

4.1.Худалдан авагч барааны төлбөрийг бэлнээр болон дансаар худалдагчид шилжүүлнэ.

4.2.Худалдан авагч барааны төлбөрийг шилжүүлснээ Худалдагчид ажлын 3 хоногийн дотор мэдэгдэнэ.

5. Бараа шилжих

5.1. Худалдсан барааг Худалдан авагчид шилжүүлснээр бараа материалтай холбоотой бүх эрсдэл Худалдан авагчид шилжих тул 2 тал барааг хүлээн авах хүлээлтгээ өгөхдөө сайтар шалгаж гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

5.2. Худалдан авагч барааг хүлээн авсныг гэрчлэх тодорхой үйлдэл хийсэн бол түүнийг бараа хүлээн авсанд тооцно.

6. Талуудын хариуцлага

6.1.Худалдагчийн буруугаас барааг хугацаанд нь шилжүүлээгүй тохиолдолд шилжүүлээгүй барааны үнийн дүнгийн 01.хувиар тогтоон Худалдан авагчид торгууль төлнө.

6.2.Худалдагчийн буруугаас доголдолтой барааг шилжүүлсэн бол уг доголдлыг арилгах үүрэг хүлээх бөгөөд доголдолтой барааны үнийн дүнгийн 20.хувиар тогтоон Худалдан авагчид торгууль төлнө.

6.3.Худалдагдсан барааны үнэ нь тухайн үеийн ижил чанар, төрлийн барааны зах зээлийн үнээс илт зөрүүтэй бол талууд барааны үнийн зөрүүг арилгах үүрэгтэй.

6.4. Энэ гэрээний нөхцлийг зөрчсөнөөс аль нэг талд шууд хохирол учирвал нөгөө тал хохирлыг арилгаж, ирээдүйд олох байсан ашгийг тооцон барагдуулна. Хохирол учирсан эсэхийг хохирогч тал батална.

6.5. Энэ гэрээний үйлчлэх хугацаанд хүлээсэн үүргээ биелүүлэхээс нэг талын журмаар үндэслэлгүйгээр татгалзсан буруутай тал нөгөө талд үнийн дүнгийн 20 хувьтай тэнцэх торгууль төлнө.

7. Давагдашгүй хүчин зүйл

7.1.Давагдашгүй хүчин зүйл (тухайлбал: үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үймээн, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт)-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно.

7.2.Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд нэн даруй нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ.

7.3.Тухайн нөхцөл байдлын улмаас гэрээний үүргийн хугацаа 30 хоногоор тойшловол талуудын аль нэг нь гэрээний үүргээ биелүүлэхээс татгалзаж болно. Энэ тохиолдолд хохирол төлүүлэхийг шаардахгүй.

8. Нэмэлт нөхцөл

9. Маргааныг шийдвэрлэх

9.1.Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ.

9.2.Талууд тохиролцоонд хүрч чадахгүй бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг (шүүх, арбитр)-аар шийдвэрлүүлнэ (доогуур нь зурах).

10. Гэрээний үйлчлэх хугацаа

10.1. Гэрээний үйлчлэх хугацаа 2016 оны 02-р сарын 02-ны өдрөөс 2018 оны 02-р сарын 02-ны өдөр хүртэл байна.

10.2. Гэрээний үйлчлэх хугацааг хоёр тал бичгээр тохиролцсоноор сунгаж болно.

10.3. Гэрээний үйлчлэх хугацааг дараахь тохиолдолд зогсоож болно:

- Талуудын зөвшилцсөнөөр,
- Монгол Улсын эрх бүхий байгууллагын шийдвэрээр,
- Давагдашгүй хүчин зүйлийн үйлчлэлээр.

11. Бусад заалт

11.1. Гэрээг 2 хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгална.

11.2.Талууд гэрээнд тусгагдаагүй асуудлыг шийдвэрлэхдээ Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

12. Талуудын хаяг

Худалдагч:

Хаяг:
 Багануур дүүрэг 1-р хороо
 "Тогосын Хөндий" ХХК
 Утас: 99999905
 Гарын үсэг: /А.Хадхүү/



Худалдан авагч:

Хаяг:
 Багануур дүүрэг 1-р хороо Баялаг
 хороолол 18 тоот
 Утас: 70213292, 99825964
 Гарын үсэг: /С.Алтантана/